



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/165

Цагаан-Уул сум

Г Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлыг хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 42 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын А/79 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Цагаан-Уул сумын “Галт дулаан” ХХК-ий Дулааны инженерийн шугам сүлжээ болон Форлонд 3800 усны машины (Улсын дугааргүй) дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: Л.Сэрсмаа (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

Гишүүн: Н.Пүрэвжаргал (Иргэдийн төлөөлөгчдын хурлын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ч.Батчимэг (“Галт дулаан” ХХК-ны нягтлан бодогч)

2. Уг дуудлага худалдааг 2024 оны 11 дугаар сарын 05-ны 11:00 цагт Цагаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын “Иргэний танхим”-д зохион байгуулсугай.

3. Дуудлага худалдааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА

Н.АЛТАНБААТАР



/Zahiramj 2024/